



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
Биелэлтийг 2023 оны 06 сарын 20 ний өдрийн 1/300 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2. Албан шаардлага.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



Баянхонгор сумын Засаг
Даргын Тамгын Газрын Дарга
Г.Хүрэлсүх танаа

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.24 № 50

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрч 147,272.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 17,390.8 мянган төгрөгөөс илүү байгаа тул Хязгаарлах дүгнэлт өгөх үндэслэл болов. Үүнд:

Баянхонгор сумын ЗДТГ нь хамт олноороо хэлэлцэн “Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх” журам боловсруулан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Баянхонгор сумын ЗДТГ-ын албан хаагчдад 14,181.0 мянган төгрөгөөр гамшгаас хамгаалах болон байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэсэн, мөнгөн хөрөнгийн урьдчилгаагаар 30,714.2 мянган төгрөгийг нярвын болон нийтлэг үйлчилгээний газрын даргын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн боловч кассын тайлан гаргаагүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар

5020345

зүйл. "Хэмнэлтийн бусад арга хэмжээ"- г, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", гэсэн хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг хэрэгжүүлээгүй. Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 87 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the Mongolian Audit Agency (МОНГОЛЫН АУДИТЫН АГЯА) and the title of the Director (ТЭРГҮҮЛЭХ). The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,644,566.38	379,758,162.45
33	АВЛАГА	15,633,546.93	3,493,618.00
335	Бусад авлага	15,633,546.93	3,493,618.00
3351	Байгууллагаас авах авлага	15,633,546.93	3,493,618.00
35	БАРАА МАТЕРИАЛ	146,011,019.45	376,264,544.45
354	Хангамжийн материал	146,011,019.45	363,153,486.45
35410	Бичиг хэргийн материал	19,163,569.11	19,700,569.11
35420	Аж ахуйн материал	67,747,878.00	247,223,345.00
35430	Сэлбэг хэрэгсэл	12,532,503.40	19,427,503.40
35470	Бусад хангамжийн материал	46,567,068.94	76,802,068.94
35600	Мал амьтад	00.00	13,111,058.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,731,654,693.08	2,309,335,187.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,731,654,693.08	2,309,335,187.89
392	Биет хөрөнгө	1,647,602,693.08	2,225,283,187.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,617,885,791.10	1,807,369,654.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-315,828,496.13	-380,368,323.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,094,800.00	122,884,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,288,720.14	-104,221,186.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	278,328,536.00	345,886,045.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-158,971,612.47	-175,596,019.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	259,739,299.58	274,929,044.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-81,530,863.11	-105,839,993.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,900,000.00	443,569,608.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,726,041.75	-3,938,541.79
39217	Ном	00.00	608,100.00
393	Биет бус хөрөнгө	84,052,000.00	84,052,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,500,000.00	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	84,052,000.00	84,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,893,299,259.46	2,689,093,350.34
413	Өглөг	248,382.64	172,810.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	248,382.64	00.00
4136	Бусад өглөг	00.00	172,810.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	172,810.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,893,050,876.82	2,688,920,540.34
51	Засгийн газрын хувь оролцоо	1,893,050,876.82	2,688,920,540.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,709,433.09	876,709,433.09
51101	Өмч: - төрийн	876,709,433.09	876,709,433.09
512	Хуримтлагдсан үр дүн	651,760,082.87	1,447,629,746.39
51210	Өмнөх үеийн үр дүн	651,760,082.87	651,760,082.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	795,869,663.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,581,360.86	364,581,360.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,893,299,259.46	2,689,093,350.34

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,838,569,629.20	4,025,248,907.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,257,701.00	817,032,029.00
120	Нийтлэг татварын бус орлого	347,257,701.00	817,032,029.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,027,200.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,027,200.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	344,831,546.00	674,288,971.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,398,955.00	142,743,058.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,491,311,928.20	3,208,216,878.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	401,346,528.20	150,107,478.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	384,529,528.20	120,699,178.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,817,000.00	29,408,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,089,965,400.00	3,058,109,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,089,965,400.00	3,058,109,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,561,200,467.42	3,198,427,243.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,561,200,467.42	3,198,427,243.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,463,819,288.89	3,062,538,749.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,183,604.24	1,144,396,332.16
210101	Үндсэн цалин	656,183,604.24	882,881,777.97
210102	Нэмэгдэл	00.00	207,479,246.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	54,035,308.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,469,144.18	123,737,210.56
210201	Тэтгэврийн даатгал	65,721,686.07	80,695,399.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,983,386.23	11,253,621.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,494,389.39	8,778,912.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,024,516.84	2,155,925.04
210205	Эрүүл мэндийн даатгал	10,245,165.65	20,853,351.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,159,698.57	93,128,160.18
210301	Гэрэл, цахилгаан	6,551,065.57	7,720,578.32
210302	Түлш, халаалт	67,451,447.00	80,635,447.86
210303	Цэвэр, бохир ус	4,157,186.00	4,772,134.00
2104	Хангамж, бараа материалын зардал	809,361,147.39	900,915,023.48
210401	Бичиг хэрэг	15,016,300.00	18,557,530.00
210402	Тээвэр, шатахуун	36,931,275.00	45,417,714.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,317,376.39	12,938,834.48
210404	Ном, хэвлэл	100,000.00	9,228,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	718,050,000.00	778,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,151,700.00	15,707,845.00

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,501,850.00	20,264,600.00
210408	Бараа материал акталсны зардал	16,292,646.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,034,620.00	31,086,250.00
210604	Урсгал засвар	6,034,620.00	31,086,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	439,750,381.00	315,203,071.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	439,750,381.00	315,203,071.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	386,860,693.51	454,072,701.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,436,040.00	292,344,524.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	9,397,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,924,653.51	152,331,176.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,381,178.53	135,888,494.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,152,500.00	54,413,401.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	9,440,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,524,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,048,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,580,000.00	44,973,401.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,228,678.53	81,475,093.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,228,678.53	77,981,475.29
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт		3,493,618.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	277,369,161.78	826,821,663.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	30,952,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	00.00	30,952,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	277,369,161.78	795,869,663.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,494,339,128.20	3,208,216,878.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,027,200.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,027,200.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,027,200.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,027,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,493,311,928.20	3,208,216,878.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	403,346,528.20	150,107,478.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	386,529,528.20	120,699,178.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,817,000.00	29,408,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,089,965,400.00	3,058,109,400.00

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,089,965,400.00	3,058,109,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,470,384,328.20	3,152,494,178.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,470,384,328.20	3,152,494,178.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,353,804,432.47	3,001,304,433.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,613,608.38	1,131,954,708.45
210101	Үндсэн цалин	659,613,608.38	838,500,108.45
210102	Нэмэгдэл	00.00	233,958,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	59,496,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,383,511.13	134,995,888.18
210201	Тэтгэврийн даатгал	56,350,624.83	90,446,664.22
210202	Тэтгэмжийн даатгал	6,629,485.18	11,283,410.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,249,828.63	8,947,328.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,779.24	2,208,553.12
210205	Эрүүл мэндийн даатгал	11,957,793.25	22,109,931.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,159,698.57	92,798,160.18
210301	Гэрэл, цахилгаан	6,230,439.57	7,720,578.32
210302	Түлш, халаалт	67,451,447.00	80,635,447.86
210303	Цэвэр, бохир ус	4,477,812.00	4,442,134.00
2104	Хангамж, бараа материалын зардал	778,989,872.39	866,899,785.48
210401	Бичиг хэрэг	12,095,000.00	11,529,550.00
210402	Тээвэр, шатахуун	32,625,000.00	45,117,714.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,356,176.39	13,125,834.48
210404	Ном, хэвлэл	100,000.00	9,228,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	718,000,000.00	778,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,813,696.00	9,098,187.00
2105	Нормативт зардал	00.00	9,858,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	9,858,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,498,860.00	38,746,000.00
210602	Тавилга	00.00	250,000.00
210604	Урсгал засвар	9,498,860.00	38,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	479,167,781.00	396,779,312.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	479,167,781.00	396,779,312.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,991,101.00	329,272,578.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,491,101.00	319,328,578.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	9,944,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,579,895.73	151,189,744.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,930,599.00	69,714,651.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,524,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,048,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,358,099.00	69,714,651.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,649,296.73	81,475,093.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,228,678.53	77,981,475.29

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,420,618.20	3,493,618.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,954,800.00	55,722,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,954,800.00	55,722,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,954,800.00	55,722,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,954,800.00	55,722,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,954,800.00	55,722,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-23,954,800.00	-55,722,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,112,092.89	-7,112,092.89
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	651,760,082.87	1,893,050,876.82
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	651,760,082.87	1,893,050,876.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	651,760,082.87	1,893,050,876.82
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	795,869,663.52	795,869,663.52
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	1,447,629,746.39	2,688,920,540.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗӨРҮҮ	Гүйцэтгэлийн хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,058,109,400.00	2,980,127,924.71	77,981,475.29	97.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,058,109,400.00	2,980,127,924.71	77,981,475.29	97.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,988,109,400.00	2,910,413,273.71	77,696,126.29	97.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,170,140,300.00	1,131,954,708.45	38,185,591.55	96.74
210101	Үндсэн цалин	876,685,700.00	838,500,108.45	38,185,591.55	95.64
210102	Нэмэгдэл	233,958,100.00	233,958,100.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,496,500.00	59,496,500.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,267,400.00	134,995,888.18	11,271,511.82	92.29
210201	Тэтгэврийн даатгал	99,461,900.00	90,446,664.22	9,015,235.78	90.94
210202	Тэтгэмжийн даатгал	11,701,400.00	11,283,410.85	417,989.15	96.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,361,100.00	8,947,328.67	413,771.33	95.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,340,200.00	2,208,553.12	131,646.88	94.37
210205	Эрүүл мэндийн даатгал	23,402,800.00	22,109,931.32	1,292,868.68	94.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,291,700.00	92,798,160.18	8,493,539.82	91.61
210301	Гэрэл, цахилгаан	11,346,100.00	7,720,578.32	3,625,521.68	68.05
210302	Түлш, халаалт	82,123,600.00	80,635,447.86	1,488,152.14	98.19
210303	Цэвэр, бохир ус	7,822,000.00	4,442,134.00	3,379,866.00	56.79
2104	Хангамж, бараа материалын зардал	878,138,800.00	867,507,885.48	10,630,914.52	98.79
210401	Бичиг хэрэг	11,384,000.00	11,529,550.00	-145,550.00	101.28

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	45,120,000.00	45,117,714.00	2,286.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,734,800.00	13,125,834.48	10,608,965.52	55.30
210404	Ном, хэвлэл	10,000,000.00	9,836,600.00	163,400.00	98.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	778,800,000.00	778,800,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,100,000.00	9,098,187.00	1,813.00	99.98
2105	Нормативт зардал	10,000,000.00	9,858,000.00	142,000.00	98.58
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	9,858,000.00	142,000.00	98.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,000,000.00	58,152,600.00	2,847,400.00	95.33
210602	Тавилга	22,500,000.00	19,656,600.00	2,843,400.00	87.36
210604	Урсгал засвар	38,500,000.00	38,496,000.00	4,000.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	288,771,200.00	285,873,452.82	2,897,747.18	99.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	288,771,200.00	285,873,452.82	2,897,747.18	99.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	332,500,000.00	329,272,578.60	3,171,421.40	98.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	332,500,000.00	319,328,578.60	3,171,421.40	98.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	9,944,000.00	56,000.00	99.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70000000.00	69714651.00	285,349.00	99.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,000,000.00	69,714,651.00	285,349.00	99.59
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,000,000.00	69,714,651.00	285,349.00	99.59
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,058,109,400.00	2,980,127,924.71	77,981,475.29	97.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,058,109,400.00	2,980,127,924.71	77,981,475.29	97.45
132001	Орон нутгийн төсвөөс	3,058,109,400.00	2,980,127,924.71	77,981,475.29	97.45
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	70.00	70.00		
620001	Удирдах ажилтан	03.00	03.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	58.00	58.00		
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,613,860.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,613,860.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,613,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,613,860.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,614,310.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	146,614,310.00

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,206,010.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,408,300.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь “Олон улсын чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн иргэд ажиллаж амьдрах таатай орныг бүрдүүлсэн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, төрийн албан хаагч, сахилга хариуцлагатай тогтвортой засаглалыг төлөвшүүлэхэд оршино ” гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,689,093.35 мянган төгрөг болж өмнөх оноос 795,794.09 мянган төгрөгөөр буюу 42.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	15,633.55	3,493.62	-12,139.93
Бараа материал	146,011.02	376,264.54	230,253.53
Үндсэн хөрөнгө	2,378,500.43	3,080,799.25	702,298.82
Хуримтлагдсан элэгдэл	-646,845.73	-771,464.06	-124,618.33
Нийт хөрөнгө	1,893,299.26	2,689,093.35	795,794.09
Өр төлбөр	248.38	172.81	-75.57
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,893,050.88	2,688,920.54	795,869.66
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,893,299.26	2,689,093.35	795,794.09

Эх сурвалж: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 3,493.62 мянган төгрөг болж өмнөх оноос 12,139.93 мянган төгрөгөөр буурсан бөгөөд өмнөх оны авлагыг бүрэн бардуулж нэмэлт санхүүжилтээс орон нутгийн орлогод төвлөрүүлсэн 3,493.6 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 230,253.53 мянган төгрөгөөр өссөн нь улсын нөөцөөс 30,952.0 мянган төгрөгийн өвс, тэжээл, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 98,680.0 мянган төгрөгийн шинэ суурьшлын бүсийн усалгааны материал, 13,111.0 мянган төгрөгийн мал шилжүүлж авсан голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,080,799.25 мянган төгрөг болж өмнөх оноос 702,298.82 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 55,722.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, Аймгийн, сумын ИТХ-ын тогтоол, шийдвэрийн дагуу 674,288.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж авсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Өмнөх оны өглөгөөс 74.5 мянган төгрөгийг барагдуулж 172.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,688,920.54 мянган төгрөг болж 795,869.66 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,314,937.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас 2 удаа тодотгол хийж 743,171.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.

Энэ нь Засгийн газраас төрийн албан хаагчийн цалинг нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 80101, 80103, 80106, 80802, 81102, 81701, 82212 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,058,109.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, нийт зардлын гүйцэтгэл 2,980,127.9 мянган төгрөг буюу 97.5 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн хэмнэлт 77,981.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,102,808.6	1,041,274.6	61,534.0	94.4
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	143,000.0	139,841.30	3,158.7	97.8
3	80106	Баг,хорооны ҮАЗардал	515,229.6	505,119.7	10,109.9	98.0
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	70,000.0	69,714.7	285.3	99.6
5	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	175,000.0	174,987.3	12.7	99.9
6	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	273,271.2	270,390.3	2,880.9	98.9
7	82212	Хур хог хаягдал, орчны бохирдол зайлуулах	778,800.0	778,800.0	0.0	100.0
Нийт			3,058,109.4	2,980,127.9	77,981.5	97.5

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтээр өмнөх оны төвлөрүүлэлтээс 15,420.6 мянга, өвсний үнэ 7362.0, хашааны үнэ 8,300.0 мянга 86,631.7 мянга, бусад эх үүсвэрээс 32,393.1 мянган төгрөг нийт 150,107.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 146,613.8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст улсын төсөвт 3,493.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

№	Орлогын төрөл	/мян.төгрөгөөр/	
		Авсан санхүүжилт	
1	Хүлэмж	86,631.76	
2	Өвсний үнэ	7,362.00	
3	Хашааны үнэ	8,300.00	
4	Авлага	15,420.62	
5	бусад эх үүсвэрээс	32,393.10	
Нийт		150,107.48	

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлогын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Номгон аудит ХХК-д аудитад шаардлагатай баримт материалыг 2024.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Г.Хүрэлсүх, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Цэрэнчимэд, 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 10 сарын 07 хүртэл, Э.Батчимэг 2023 оны 10 дугаар сарын 07-ээс 2023 оны 12 сарын 31 хүртэл зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,310,348.6 мянган төгрөгөөс 23,187.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 17,390.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. "Хэмнэлтийн бусад арга хэмжээ"- г, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно". гэсэн заалтуудыг зөрчиж. Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын албан

хаагчдад 14181.0 мянган төгрөгөөр гамшгаас хамгаалах, байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Мөн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 65,774.6 мянган төгрөгийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам боловсруулан зориулалтаар зарцуулж хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,058,109.4 мянган төгрөгийн 68 гүйлгээ, зарлагын 1,147,937.0 мянган төгрөгийн 64 гүйлгээ мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 7,186.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 6,651.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага 15,599.5 мянган төгрөгийн алдаа зөрчил ил алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	7186.4	2	7186.4	100
Албан шаардлага	2	6651.1	2	6651.1	100
Зөвлөмж	1	15,599.50	1	15,599.50	100
Нийт дүн	5.00	29,437.00	5.00	29,437.00	

Биелэлтийг 2023 оны 06 сарын 20 ний өдрийн 1/300 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор сумын ЗДТГ нь хамт олноороо хэлэлцэн “Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх” журам боловсруулан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан. Баянхонгор сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт зэргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаар шалгуулах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 147,272.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 17,632.8 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 129,639.5 мянган төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

5.1.1 Баянхонгор сумын ЗДТГ-ын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих “Баянхонгор сумын 2023 онд ногоон байгууламж нэмэгдүүлсэн ойн зурвасуудад цас овоолж модны нүх дүүргэх овоолох ажлыг хийж гүйцэтгэх гэрээ”-г Баянхонгор сумын Засаг дарга, иргэн Б.Оюунгэрэл нар 2023 оны 12 дугаар сарын 15 өдөр байгуулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 12,600.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 БТОЗ ХХК-д цэрэг татлагын хулдаасан хэвлэлийн зардал 144.0 мянган төгрөгийг 2 удаа давхардуулан шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”; гэсэн заалт, ангилал үнэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 144.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Тайланд онд албан хаагчдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг Баянхонгор аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүйгээс 4,788.9 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө

оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”; гэсэн заалт, ангилал үнэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын хэлтэст илүү төлсөн 4,788.8 мянган төгрөгийг 2024 оны ХХОАТ-ын зардлаас суутган тооцож төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.1 Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь 2023 оны 12 дугаар сарын 10 ний өдрийн 54 тоот тушаалаар албан хаагчдад түлшний хөнгөлөлт олгохдоо тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж 100.0 мянган төгрөгийг авсан.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 100.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2. Албан шаардлага

Илрүүлэлт:

5.2.1 Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанаас Баянхонгор сумын ЗДТГ-т бүртгэлтэй 6409009222, 6409010521 нэгж талбарын дугаар бүхий 5200 м² талбай бүхий газар санхүүгийн тайланд тусгагдаагүй зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд 6409009222, 6409010524 нэгж талбарын дугаар бүхий газрыг биет бус хөрөнгөнд нэмж бүртгэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 14181.0 мянган төгрөгөөр гамшгаас хамгаалах, байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”. гэсэн заалтыг зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Тайлант хугацаанд багийн Засаг дарга Г.Нямдаваа, мэргэжилтэн Г.Гүндалай нарт 4, 12 дугаар саруудад ажилласан хоногт ноогдох 299.6 мянган цалин бодож олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3-т "ажилтны үндсэн эрх үүргийн ...гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах"; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан хаагчдын цалинг нөхөн тооцож олгож зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Ажиллагсдын цалинг бодохдоо 2023 оны 11, 12 дугаар сард давхардсан тоогоор 66 албан хаагчаас суутгасан 3,870,000.00 (Гурван сая найман зуун далан мянган) төгрөгийн хамтын сангийн төлбөрийг цалингийн программд цалин дээр олгохоор тооцсон дүнг бууруулан оруулснаас ХХОАТ-ыг суутган тооцоогүй, НДШ-ийн мэдээнд мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх", ХХОАТ-ын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, ...-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтуудыг зөрчсөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан хаагчдын цалинг нөхөж мэдээлж дутуу суутгасан НДШ-н 445050 төгрөг, ХХОАТ-ын 342495 төгрөгийг суутган тооцож төлөх шимтгэлийг төсөвт төвлөрүүлэх байгууллагаас төлөх НДШ-ыг нөхөн тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09 ний өдрийн 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын Б/25 тоот захирамжаар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч байсан Б.Ишмаад ажилгүй байсан хугацааны цалинд 11,530.1 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс олгосон 11,530.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.6 Тайлант хугацаанд гүйлгээгээр 30,714.2 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад сумын Төрийн сангийн мэргэжилтэн, албаны дарга нар гүйлгээг баталж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.6. "Анхан шатны

баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллах, , анхан шатны баримтыг бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийхгүй байх, анхан шатны баримтгүй бүрдэл дутуу хийгдсэн гүйлгээнүүдийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.7 Байгууллагын даргын 2023.03 .01-ны өдрийн Б/29 дугаар тушаалаар Ц.Нансалмаагийн жирэмсний, амаржсаны амралттай байсан хугацаанд ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2023 оны 4,5,6 дугаар сард мэдээлээгүй, 2023.07 .03-ны өдрөөр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн Х.Нямсүрэнгийн цалин 1,650.0 мянган төгрөгийг НДШ-ийн мэдээнд 7,8,9 дүгээр сард илүү мэдээлж нийт цалингийн зардлаас 3,300.0 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна..

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалд илүү дутуу мэдээлсэн 3,300.0 мянган төгрөгийн шимтгэлийн тооцоо хийж залруулж мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.8 Баянхонгор сумын “Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам” боловсруулан Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 02 дугаар сарын 09 ний өдрийн хамт олны хурлаар баталж нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 65,774.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. "Хэмнэлтийн бусад арга хэмжээ"-г, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29 өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баянхонгор сумын “Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх” журмыг хүчингүй болгох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Ажиллагсдын цалинг бодохдоо нягтлан бодогч 2023 оны 11, 12 дугаар сард давхардсан тоогоор 66 албан хаагчаас суутгасан 3,870,0 төгрөгийн хамтын санг суутгалыг цалингийн программд цалин дээр нэмэгдэл талд хасах тэмдэгтэй суутган тооцож цалинг дээрх дүнгээр Нийгмийн даатгалд цалинг дутуу мэдээлсэн	1	3,870.0			1	3,870.0		
Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09 ний өдрийн 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын Б/25 тоот захирамжаар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч байсан Б.Ишмаад ажилгүй байсан хугацааны цалинд 11,530.1 мянган төгрөгийг олгосон.	1	11,530.1			1	11,530.1		
Тус газрын Тамгын газрын дарга нь нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тушаалын хавсралтад нэр оруулж 100.0 мянган төгрөгийг авсан.	1	100.0	1	100				
Тайлант хугацаанд багийн Засаг дарга Г.Нямдаваа, мэргэжилтэн Г.Гүндалай нарт 4, 12 дугаар саруудад ажилласан хоногт ноогдох 299.6 мянган цалин бодож олгоогүй байна	1	299.6			1	299.6		
Тайлант хугацаанд гүйлгээгээр 30,714.2 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад сумын Төрийн сангийн мэргэжилтэн, албаны дарга нар гүйлгээг баталж зарцуулсан	1	30,714.2			1	30,714.2		
5.1.2 БТОЗ ХХК-д цэрэг татлагын хулдаасан хэвлэлийн зардал 144.0 мянган төгрөгийг 2 удаа давхардуулан шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	144.0	1	144.0				
Байгууллагын даргын 2023.03 .01-ны өдрийн Б/29 дугаар тушаалаар Ц.Нансалмаагийн жирэмсний, амаржсаны амралттай байсан хугацаанд ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2023 оны 4,5,6 дугаар сард мэдээлээгүй, 2023.07 .03-ны өдрөөр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн Х.Нямсүрэнгийн цалин 1,650.0 мянган төгрөгийг НДШ-ийн мэдээнд 7,8,9 дүгээр сард илүү мэдээлж нийт цалингийн зардлаас 3,300.0 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна	1	3,300.0			1	3,300.0		

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор сумын ЗДТГ-ын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих "Баянхонгор сумын 2023 онд ногоон байгууламж нэмэгдүүлсэн ойн зурвасуудад цас овоолж модны нүх дүүргэх овоолох ажлыг хийж гүйцэтгэх гэрээ"-г Баянхонгор сумын Засаг дарга, иргэн Б.Оюунгэрэл нар 2023 оны 12 дугаар сарын 15 өдөр байгуулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй.	1	12,600.0	1	12,600.00				
Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанаас Баянхонгор сумын ЗДТГ-т бүртгэлтэй 6409009222, 6409010521 нэгж талбарын дугаар бүхий 5200 м2 талбай бүхий газар санхүүгийн тайланд тусгагдаагүй зөрүүтэй	1				1	-		
Тайланд онд албан хаагчдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг Баянхонгор аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүйгээс 4,788.9 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй	1	4,788.8	1	4788.8				
Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 65774.6 мянган төгрөгийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам боловсруулан зориулалтаар зарцуулсан.	1	65,744.6			1	65,744.6		
Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 14181.0 мянган төгрөгөөр гамшгаас хамгаалах, байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	14,181.0			1	14,181.0		
Нийт дүн	12	147,272.3	4	17,632.8	8	129,639.5	-	-

oOo



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 180 / 14210513 / БНА / 2024
/ 171 / НА - СТА - ТУ13 /

Номгон

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд албан хаагчдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг Баянхонгор аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүйгээс 4,788,882 (Дөрвөн сая долоон зуун наян найман мянга найман зуун наян хоёр) төгрөгөөр илүү шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "Дансны өглөг авлага ба төлбөр тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах, 20.2.7-т "Аж ахуйн нэгж байгууллагын татвар төлбөр хураамж шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийг үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэсэн заалт, ангилал зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050337

1. Илүү шилжүүлсэн ХХОАТ 4,788,882.00 /Дөрвөн сая долоон зуун наян найман мянга найман зуун наян хоёр/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 182 /14210513/БНН/2024
1171/НН-СГА-ТШЗ

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ЗДТГ-ын дарга нь 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 54 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өөртэй шийдвэр гарган 100,000 төгрөгийн тэтгэмж авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр олгосон 100,000.00 /Нэг зуун мянган/ төгрөгийг тухайн үед төсвийн шууд захирагчаар ажиллаж байсан Г.Хүрэлсүхээр


5050373

төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ТАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 118/14210513/БТН/2024
1171 НН-СТН-ТМБ1

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын бараа үйлчилгээний бусад зардлаас БТОЗ ХХК-д цэрэг татлагын арга хэмжээнд зарцуулсан хулдаасан хэвлэлийн зардлын 144,000.00 (Нэг зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийг нягтлан бодогч Б.Цэрэннадмид 2023 оны 05 дугаар сарын 04 өдөр давхардуулан шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэсэн заалт, ангилал үнэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү шилжүүлсэн 144,000.00 (Нэг зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийг төсвийн нягтлан бодогч Б.Цэрэннадмидаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор

5050331

аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 119 /АА105ТЗ / БНА / 2024

Номгон

/ 171 / НА-СТА-7ШЗ /

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын ЗДТГ-ын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих “Баянхонгор сумын 2023 онд ногоон байгууламж нэмэгдүүлсэн ойн зурвасуудад цас овоолж модны нүх дүүргэх овоолох ажлыг хийж гүйцэтгэх гэрээ”-г Баянхонгор сумын Засаг дарга, иргэн Б.Оюунгэрэл нар 2023 оны 12 дугаар сарын 15 өдөр байгуулсан байна.

Аудитаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь “Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050334

1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зориулалт бусаар зарцуулсан 12,600,000 /Арван хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 03 дугаар сарын 5-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 195 / 14210513 / БНН / 2024

Номгон

1171 / НА-СТН-ТШБ /

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ЗДТГ-ын албан хаагчдад 14,181,000 (Арван дөрвөн сая нэг зуун наян нэгэн мянган) төгрөгөөр гамшгаас хамгаалах арга хэмжээнд зориулсан хувцас, байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040591

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 219 / 14210513 / БНН / 2024

Номгон

1171 / НА - СТА - ТЦБЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хамт олны хурлаар “Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам” баталж нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 65,774,600.00 (Жаран таван сая долоон зуун далан дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийг дээрх журмыг үндэслэн төсвийн хөрөнгийн зориулалт бусаар зарцуулсан байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл “Хэмнэлтийн бусад арга хэмжээ”-г, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журмыг хүчингүй болгон зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 04 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040693

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХҮК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 200 /142105131 БНА/2024
/ 171 / НА-СТА-Т203 /

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй газрыг Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 6409009222, 6409010524 нэгж талбарын дугаар бүхий 5200м² (Есөнбулаг-9, Дуурсах-3 багуудын Төр захиргааны байгууллага) газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд 6409009222, 6409010524 нэгж талбарын дугаар бүхий газрыг биет бус хөрөнгөнд эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн бүртгэж зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд

5040606

оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:

Г.САРАНЧИМЭГ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 201 /142105131 БНА/2024
141) НА-СТА-ТЦЗ1

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын таамгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдын цалинг бодохдоо 2023 оны 11, 12 дугаар сард давхардсан тоогоор 66 албан хаагчаас суутгасан 3,870,000.00 (Гурван сая найман зуун далан мянган) төгрөгийн хамтын сангийн төлбөрийг цалингийн программд цалин дээр олгохоор тооцсон дүнг бууруулан оруулснаас ХХОАТ-ыг суутган тооцоогүй, НДШ-ийн мэдээнд мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Ажилдагсдын цалингаас Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас өөр төрлийн суутгал суутгасан.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл "Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх", ХХОАТ-ын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, ...-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтуудыг гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан

5040609


зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Хамтын санд төлсөн 3,870,000.00 төгрөгийн цалингийн зардлаас тооцсон НДШ 445,050.00 (Дөрвөн зуун дөчин таван мянга тавин) төгрөг, суутган тооцох ХХОАТ 342,495.00 (Гурван зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун ерэн таван) төгрөгийг холбогдох байгууллагад шилжүүлэн зөрчлийг арилгах.

2. Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар өөрөөр суутгаж байгаа хамтын сангийн мөнгийг суутгадаг байдлыг таслан зогсоох.

3. Биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХҮК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 198/11410513/БИА/2024

Номгон

1171/НА-СТН-ТШЗ |

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд харилцах данснаас 30,714,200 төгрөгийн гүйлгээг байгууллагын нярав, нийтлэг үйлчилгээний даргын хувийн харилцах дансаар дамжуулан хийсэн боловч кассын дэлгэрэнгүй тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна. гэсэн заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040600

1. Бэлэн мөнгөний урьдчилгааны тайлан гарган, Баянхонгор сумын Төрийн сангийн санхүүгийн албаны даргаар хянуулж баталгаажуулан, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг, Санхүүгийн албаны дарга Д.Оюун-Эрдэнэ нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨТСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

6117148544
BIC: UOCC220007423

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 197 /14210513/ БНА /2024
/ 171) НА - СТА - ТШЗ)

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09 ний өдрийн 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын Б/25 тоот захирамжаар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч байсан Б.Ишмаад ажилгүй байсан хугацааны цалинд 11,530,100 (Арван нэгэн сая таван зуун гучин мянга нэг зуун) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалт, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шүүгчийн захирамжийг үндэслэн төсвөөс төлсөн 11,530,100 (Арван нэгэн сая таван зуун гучин мянга нэг зуун) төгрөгийг Баянхонгор сумын Засаг даргаар ажиллаж байсан иргэн Ж.Мөнхсоёлоор нөхөн төлүүлж төрд учирсан хохирлыг


5040597


барагдуулж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 196 / 14810513 / БНН / 2024
/ 171 / НЯ-СТН-ТШЗ /

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч Б.Цэрэннадмид нь цагийн бүртгэлээр бүрэн ажилласан байхад багийн Засаг дарга Г.Нямдаваа, мэргэжилтэн Г.Гүндалай нарт 4 ба 12 дугаар саруудад ажилласан хоногт ноогдох 299,600.00 (Хоёр зуун ерэн есөн мянга зургаан зуун) төгрөгийн цалин бодож олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйл "Ажилтны үндсэн эрх үүрэг"-ийн 42.1.3-т "Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" гэсэн заалтыг зөрчсөн байна. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэн, дээрх ажилтнуудын цалинг тооцон олгож, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


5040594

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 199 /14210513/ БНА/2024

Номгон

1171 МА-СТН-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2023 онын 03 дугаар сарын 01-ны өдрийн Б/29 дугаар тушаалаар Ц.Нансалмаагийн жирэмсний, амаржсаны амралттай байсан хугацаанд ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2023 оны 4,5,6 дугаар сард мэдээлээгүй, 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн Х.Нямсүрэнгийн цалин 1,650,000.0 төгрөгийг НДШ-ийн мэдээнд 7,8,9 дүгээр сард илүү мэдээлж нийт цалингийн зардлаас 3,300,000 төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,1 дэх ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх", 21.1 "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтуудыг гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11


5040603

дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Ц.Нансалмаагийн жирэмсний, амаржсаны амралттай байсан хугацааны ажил олгогчоос төлөх НДШ-ийг хуулийн дагуу тооцсон нөхөн мэдээлж, үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн иргэн Х.Нямсүрэнгийн илүү тооцсон НДШ-ийн мэдээг залруулж, Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлэн зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Хүрэлсүх, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  Г.САРАНЧИМЭГ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно